



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар A/189

Мандалговь

Бүх нийтийн цэвэрлэгээ
тогтмол зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л", 31 дүгээр зүйлийн 31.1.7, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ нь:

1. Мандалговь хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд сар бүрийн сүүлийн долоо хоногийн "Баасан" гарагт төсөвт болон аж ахуй нэгж байгууллага, Төвийн 5 багийн айл өрхүүд долоо хоногийн "Баасан" гарагт Мандал, Айраг, Арвижих, Боржигон, Нарлаг баг гэсэн дарааллаар сард нэг удаа бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг тогтмол зохион байгуулсугай.

2. Аж ахуй нэгж байгууллагууд орчны 50 м газраа цэвэрлэх, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд аж ахуй нэгж, байгууллагууд, иргэдийг өргөнөөр татан оролцуулан зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг бологсугай.

3. Их цэвэрлэгээнээс гарсан болон үүсмэл хог хаягдлыг цаг хугацаанд нь тээвэрлэх ажлыг багуудтай хамтран зохион байгуулахыг Хот тохижуулах газрын дарга /Д.Очбадрах/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /И.Эрдэнэцог/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ